

## ҮНЭЛЭМЖИЙН ФИЛОСОФИ ҮҮСЭХ УРЬДЧИЛСАН НӨХЦЛИЙН ТУХАЙД

Т.Дорждагва /зөвлөх профессор, доктор (Ph.D)/  
Б.Гантөмөр /зөвлөх профессор, доктор (Ph.D)/  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

*Түлхүүр үг:* Аксиологи, үнэлэмж, үнэлэмжийн философи, value, Wert, ценность,

*Товч утга:* “Үнэлэмжийн философи үүсэх урьдчилсан нөхцлийн тухайд” сэдэвтэй энэхүү өгүүллийг зохиогчид үнэлэмжийн тухай ойлголтыг түүхэн тодорхой үеэр тодорхойлон гаргаж, уг сэдвийн чиглэлээр урд өмнө нь судлаачдын бичиж нийтлүүлсэн бүтээл дэх үзэл баримтлалынх нь талаар саналаа илэрхийлжээ. Үүнтэй холбогдуулан эл өгүүллийг зохиогчид дөрвөн дүгнэлтийг хийсэн байна.

Манай орон ардчилал, зах зээлийн харилцаанд орж, нээлттэй улс орон болсноор нийгмийн амьдралын бүхий л салбартаа урд өмнө үзэгдээгүй ихээхэн өөрчлөлтийг хийж ирсэн билээ. Түүний дотор боловсролын салбарт хийсэн шинэчлэлт нь харьцангуй хурдацтай явж ирсэн гэж үзэж болох байх. Дан ганц нэг үзэл суртлын хүрээнд танин мэдэхүй, хүний үйл ажиллагаа үндсэндээ түүнээс хараат байж, сэтгэлгээний чөлөөт эрэл хайгуул хомсдож байсан нь үнэн ажээ. Бид үүнийг ахуйн олон хүрээнээс олж харж болох ч энэ удаа философи сэтгэлгээнд холбогдох зарим нэг асуудалд анхааралаа хандуулсан болно.

1990-ээд он хүртэл манайд зөвхөн “Марксист-Ленинист философи” хэмээх нэртэй хичээлийг зааж, түүнтэй нэгэн цаг үед үүсэн бүрэлдсэн болон түүнээс хойш буй болсон, өөрөөр хэлбэл XIX зууны сүүлчийн хагас хийгээд XX зууны эхэн, дунд үеүдэд мэндэлсэн уламжлалт бус философийн чиглэл, урсгалуудыг үл ойшоохоор үл барам тэдгээрийг

“хөрөнгөтний” гэж гоочлон сурах бичгүүдийнхээ<sup>1</sup> эцэст “Орчин үеийн хөрөнгөтний философийг шүүмжлэх нь”, “Орчин үеийн хөрөнгөтний социологийг шүүмжлэх нь” гэж гарчиглан оруулаад албан ёсоор зааж байсан юм. Энэ бүхэн нь үндсэндээ ЗХУ-ын их, дээд сургуулиудад заадаг хичээлүүдийн сурах бичгийн<sup>2</sup> хуулбар байлаа. Харин “Марксист-Ленинист философи. Түүхийн материализм” гэдэг сурах бичигтээ тухайн үзэл сурталд нийцүүлэн монголын нийгмийн амьдралын жишээнүүдийг оруулаад “зохиомжлон орчуулсан” гэж үзсэн байдгийг дурдах нь зүйтэй юм.

Монгол улс 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа батлан гаргаж

<sup>1</sup> Марксист-Ленинист философи. Дialeктик материализм. –УБ., 1971.; Марксист-Ленинист философи. Түүхийн материализм. –УБ., 1973.; Марксист-Ленинист философи. Дialeктик материализм. –УБ., 1981.; Марксист-Ленинист философи. Түүхийн материализм. –УБ., 1983.; Марксист-Ленинист философийн үндсүүд. УБ., 1983. зэргийг үзнэ үү.

<sup>2</sup> Энд жишээ болгож бараг жил болгон хэвлэгдэж байсан хоёр номыг төлөөлүүлэхэд хангалттай байхаа. Үүнд: Марксистско-Ленинская философия. Дialeктический материализм. Издание третье, доработанное. -М.: Издательство “Мысль”, 1974.; Марксистско-Ленинская философия. Исторический материализм. Издание третье, доработанное. -М.: Издательство “Мысль”, 1971.

олон ургалч үзэл бид бүхний өдөр тутмын хэрэглээний ердийн хэм хэмжээ болсон бөгөөд боловсролын тогтолцоонд шинэчлэл хийх таатай нөхцөл бүрэлдсэн байна. Энэ зорилгоор бүх шатны сургуулийн хичээлийн бүтэц, агуулга, цаг дэс дараалалд өөрчлөлт оруулж, шинэ хичээлүүдийг заах боломжтой болсон билээ. Энд уг өгүүллийн агуулгатай холбогдуулан урьд өмнө нь “хөрөнгөтний үзэл суртал” хэмээн цоллогдож, адлагдаж байсан “Соёлын онол”, “Соёл судлал”, “Соёлын философи”, мөн “Үнэлэмжийн онол”, “Үнэлэмжийн философи” зэрэг хичээлийг нэрлэж болох юм<sup>3</sup>. Бид энэ удаад үнэлэмжийн философитой холбоотой асуудлыг авч үзэх саналтай байна.

Олон улсын хэлэнд “Аксиологи” (axio-үнэлэмж, logos-үг, сургаал) хэмээн нэрлэгдэх энэхүү мэдлэгийн салбар нь философийн хамгийн залуу салбарын нэг бөгөөд XIX зууны сүүлчээр биеэ даасан салбар ухаан болж үүсэн бүрэлджээ. Түүнийг бид “Үнэлэмжийн философи” гэж нэрлэх саналтай байгаа ба энэ нь зарим нэг шалтгаантай байгаа юм. Учир нь Value, Wert, Ценность гэсэн англи, герман, орос үгийг<sup>4</sup> тухайлсан мэргэжлийн бус, нийтэд зориулсан толь бичгүүдэд, тухайлбал, үнэ, үнэ цэнэ, өртөг, ашиг тус, ач холбогдол, эрхэмлэх зүйл, үнэт чанар, үнэлэмж гэх мэтээр монгол хэл рүү орчуулсан нь бий.

Гэтэл дээр дурдсан гурван хэлний

<sup>3</sup> Ийм маягийн хэлмэгдэл өөр бусад олон ухаанд холбогдох байх. Тухайлбал энд зөвхөн хүн судлал, урлаг судлал, электроникийн салбарыг дурдахад л хангалттай буй заа.

<sup>4</sup> Д.Алтангэрэл. Англи монгол толь. – УБ.: Интерпресс, 2001.– 532 дахь талд; Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. УБ., 1982. 793 дахь талд; Ц.Цэдэндамба. Монгол-орос-англи толь. – УБ., 1986. 244 дэх талд; Oxford Monсудар. English-Mongolian Dictionary. УБ., 2006. 811 дэх талд; Э.Чинбат. Англи-Монгол толь. УБ.: Цээл эрдэнэ, 2001.

толиудыг<sup>5</sup> үзвэл уг нэр томъёо харьцангуй хатуу хадаастай байгаа нь харагдаж байна. Мөн англи хэлнээс англиар тайлбарласан нэгэн тольд<sup>6</sup> “Value” гэдгийг “хэн нэгэний хувьд ямар нэг юмны ач холбогдол болон үнэ цэнэ ... ашигтай, эсвэл чухал зүйл”, “ямар нэг зүйлийг авах мөнгөний хэмжээ” гэх мэтээр тайлбарласан байна лээ.

Тэгэхлээр эл нэр томъёо нь мэдлэгийн олон салбарт хэрэглэгддэг тул ялгаатай орчуулж хэрэглэх шаардлага байгаа байж магадгүй. Гэвч хүмүүнлэгийн ухаанд, ялангуяа философи, соёл судлал зэрэгт “үнэлэмж” гэдэг үгийг категори болгон ашиглах нь зүйтэй мэт. Ердийн ухамсрын түвшинд уг нэр томъёог ихэвчлэн “үнэт зүйл”, “үнэтэй юм” гэхчлэн биет бодитой юм, материаллаг зүйлтэй хольж ойлгоод байгаа нь алдаа юм. Сүүлийн үед манай хэд хэдэн судлаач үнэлэмжтэй холбогдох асуудлаар эрдмийн зэрэг хамгаалах буюу бүтээл туурвин<sup>7</sup> энэхүү алдааг засаж, улмаар нийтийн ухамсарт өөрчлөлт оруулж “үнэлэмж” гэдэг ойлголт зохих байр сууриа эзлэх болж ирсэнд сэтгэл хангалуун байна.

Сайн, буян, сайхан, ариун дагшин

<sup>5</sup> А.Винокуров. Англо-русский, Русско-английский словарь. М.: Мартин, 2014.;

<sup>6</sup> Краткий русско-немецкий и немецко-русский словарь. – М.: Государственное издательство иностранных и национальных словарей, 1958.; Русско-английский словарь. Russian-English dictionary. – Moscow: Soviet encyclopedia publishing house, 1970.; Collins Gem. German dictionary. German-English, English-German. – London and Glasgow, 1988.; Collins Gem. Russian dictionary. Русско-английский, Англо-русский. – Glasgow: Harper Collins publishers, 2009.

<sup>7</sup> Cambridge Advanced Learner's Dictionary. – Cambridge, New-York, Melbourne, Madrid: Cambridge University Press, 2003. – 1409 дэх талд үзнэ үү.

<sup>8</sup> Үнэлэмжийн тухай Ц.Баатартогтох, Ц.Гомбосүрэн, Т.Дорждагва, Д.Мандах, Л.Одонтуяа, Ц.Цэцэнбилэг, Г.Чулуунбаатар зэрэг судлаачдын өгсөн тодорхойлолтыг Т.Дорждагва. Соёл судлал. Сурх бичиг. – УБ.: БИППРЕСС, 2013. сурх бичгийн 73-74 дэх талд үзнэ үү.

гэх мэт үнэлэмжийн янз бүрийн төрлийн тухай бодомжийг эртний Грек, Ромын сонгодогууд, Дундад зууны теологууд, Сэргэн мандалтын үеийн сэтгэгчид, Шинэ үеийн философичдын бүтээлээс олж үзэж болно. Гэхдээ үнэлэмжийн тухай нэгтгэн боловсруулсан төсөөлөл, философийн янз бүрийн тодорхой хэлбэрүүдэд түүний илрэх зүй тогтлын тухай асуудал XIX зууны дунд үе хүртэл буй болж чадаагүй байна. Энэ тухай ОХУ-ын философич М.С.Каган: “Ийм учраас эртний Грек, Ром болон Дундад зуунд үнэлэмжийн янз бүрийн төрлийн тухай төсөөлөл буй болсон гэж үзсэн Ф.-Й. фон Ринтеленей *“Европын оюуны хөгжил дэх үнэлэмжийн тухай ойлголт”* хэмээх суурь судалгааны нэр нь Л.Столовичийн *“Эстетик аксиологийн тухай түүхэн найруулал”* гэдэг номын гарчиг адил бүрэн дүүрэн зөв болоогүй байна”<sup>8</sup> гэж бичжээ. Яагаад гэвэл түүний үзсэнээр XIX зуун хүртэлх этик, эстетик, теологи, философи сэтгэлгээний хувьд “аксиологи”-ийг үнэлэмжийн тухай философи онол гэж ч, ерөөс үнэлэмжийн тухай ёсоор нь ярих эрхгүй ажээ. Бас үнэлэмжийн тухай философи судалгааны түүхч А.Штерн энэ тухай “Платон, Аристотель болон бусад агуу их философичид этик, эстетик, эдийн засгийн болон бусад онолын асуудлыг боловсруулахдаа үнэлэмжийг авч үзэж байсан нь эргэлзээгүй, гэхдээ тэд сайн, сайхан, ашиг гэх мэтэд ямар нэг ерөнхий тал байгааг, энэ нь биеэ даасан судалгааны судлагдахуун болох ёстой гэдгийг ухамсарлаагүй”<sup>8</sup> гэсэн байна. Грекчүүдийн “калокагати” (calos- сайхан,

cagathos-зан суртахууны) гэдэг гэдэг ойлголт нь үнэлэмжийн ухамсрын тухай анхдагч синкретизмын үлдэгдэл байсан ба харин Сократ, Платон нарын эргэцүүлэл энэ этик, эстетикийн синкретизмийг даван туулсан гэж үзэх нь бий.

Эртний Грек, Ромын сэтгэгчдэд зан суртахууны, эстетикийн, улс төрийн, тэрч байтугай шашны ухамсар зэрэг соёлын “эпифеноменууд” тийм нэг захын, эсвэл завсрын (маргиналь) чанартай, нэмэлт үзэгдэл байсан ба сайндаа хүнээс Логосыг тээгчийг олж үзээд Протагорын сонгодог томъёолол ёсоор “бүх юмсын хэмжүүр” л гэж харсан бололтой. Грекийн философи нь материалист болоод идеалист сургаалийн ялгаа, софистуудын релятивизм болоод Платоны абсолют идеализмын эсрэг тэсрэг байдлын нөхцөлд (Аристотелийн онолын хатуу дискурсийг үл харгалзвал) чухам рационалист философи, бүр бурхдын ертөнцийг тодорхойлж томъёолсон шидэт домог, Лукрецийн үзсэнээр бол байгалийг танин мэдэх арга юм.

Өмнөх үеүдэд сайн, сайхан, буян, гайхамшиг болон соёлын бусад тодорхой үзэгдлийн тухай төсөөлөл гарамгай сэтгэгчдийн эргэцүүллийн судлагдахуун болж байсан хэдий ч салангид тусгаарлагдмал үзэгдэл байж шинжлэгдсэн ба өөрөөр хэлбэл нэгдмэл эхлэлийн тодорхой илрэл гэж ухварлагдаагүй байжээ. Хүний үнэлэмжийн ухамсарын янз бүрийн илрэлийн нэгдлийн тухай ойлгохуй нь оюун ухаан болон хүн төрөлхтөний амьдрал хийгээд хөгжилд түүний гүйцэтгэх үүргийн тухай философи төсөөллөөс нэлээд хожуу буй болсон байна. Харин “Үнэлэмжийн

<sup>8</sup> Каган М.С. *Философская теория ценности*. –СПб.: ТОО ТК “Петрополис”, 1997. номын 9 дэх талд.

ертөнц”-ийн тухай ярихдаа А.Уайтхед: Би Л.Столовичийн адил энэ нэгдлийг соёлын аксиосфер гэж нэрлэх болно<sup>9</sup> гэсэн байдаг.

Итгэл бишрэлийг оюун ухаанаас дээгүүр тавьдаг Дундад зууны менталь чанар нь иррациональ төрхтэй бөгөөд христийн теологи сэтгэлгээг үнэлэмжийн онолыг боловсруулахад хүргэх учиртай байсан байх. Шашны ухамсар өөрийнхөө төрхөөр үнэлэмжийн онолын хэлбэр болдог ба өөрийгөө тэгэж ухамсарлах ёстой байжээ. Гэтэл эртний Грек, Ромын сэтгэгчдийн нэг адил Дундад зууны философич, теологичдод үнэлэмжийн янз бүрийн төрлийн тухай салангид, ов тов санаа хэлсэн нь тааралдах ч үнэлэмжийн уг чанарын талаарх бүхэл бүтэн, түүний тодорхой хувилбаруудыг нэгтгэсэн төсөөлөл угтаа үгүйлэгдэж байгаа болно. Үүний энгийн нэг шалтгаан бол теологичдод ганцхан жинхэнэ үнэлэмж буюу бурхан тэнгэр л илэрхий байдагт оршино. Зан суртахууны, эстетикийн, улс төрийн тэр байтугай үнэн шашны ухамсрын хувьд зөвхөн бурхан тэнгэрийн эманаци<sup>10</sup>, бурхан тэнгэрийн оюуны энерги, чанад ертөнцийн тунхаглал байдаг. Энэ бол теологи ухралт, өөрөөр хэлбэл аксиологи теологид ууссан болохыг харуулж байна гэлтэй. Харин энэ үед “үнэн, сайн, сайхан” хэмээх гурвал философи сэтгэлгээ, судалгааны эргэлтэнд орж ирсэнийг тэмдэглүүштэй юм. Энэ нь Лейбниц, Соловьев нарын үзэл, бас тэдний хойч үеийнхэнээр дамжин ХХ зууны олон аксиологи сургаалд уламжлагджээ. Дээр нэрийг нь дурдсан эрдэмтэн Л.Столович “Энэ гурван ойлголт органик холбоотой,

иймээс үнэн нь сайхан бөгөөд ач буянтай, сайн нь үнэн бөгөөд сайхан, харин сайхан нь үнэн бөгөөд ач тустай (буянтай, сайн)”<sup>11</sup> гэж өөрийн үзлийн зүйтэйг нотлож, боломжтой гэж үзжээ. Гэтэл М.Вебер түүний үзлийг эрс үгүйсгэсэн байдгийг энд цухас дурдууштай.

Шашны философи, теологид, ер нь шашны ухамсарт үнэлэмжийн тухай онолыг бүтээх хэрэгцээ байдаг, эсэх нь маргаантай асуудал байж болно, яагаад гэвэл энд үнэлэмж нь ариун дагшин, мэдрэхүйгээс дээгүүрх, бурхан тэнгэрлэг төсөөлөл бүхий зөвхөн шашны хэлбэрээр өгөгддөг ба харин үнэлэмж, үнэлэмжийн ухамсрын бүх тодорхой илрэлийн хоорондох ялгаа нь жинхэнээр бус, өнгөн талын, цэвэр хэлбэрийн чанартай байдаг гэсэн судлаачдын шүүмж элбэг үзэгдэх нь бий. Энд санаваартан, сүсэгтэн болоод атейстуудын хоорондох үнэлэмж ялгаатай болох тухай санаа илт харагдаж байна.

Сэргэн мандалтын үед Дундад зууны теоцентризмд тухайн нийгмийн шинэ давхрааны буюу хотынхоны байгаль төвт үзэл болон хүмүүнлэгийн төсөөллийг сөргүүлэн тавьсан байдаг, өөрөөр хэлбэл эртний Грек, Ромын хот улсын шашны бус философид эхлэлээ тавьсан тэр үзэл санаанд буцаж ирсэн гэж үзэхээр байдаг. Юуны түрүүнд зан суртахууны, эстетикийн эрх болоод улс төрийн ухамсрын мистик<sup>12</sup> төрхийг бус, газар дэлхийн тухай төсөөллийг сэргээн авч, тэгсэнээрээ ертөнцөд харьцах хүний

<sup>11</sup> Энэ нь Бурхан тэнгэрийн бүтээлч энерги ид шидээр дуусах замаар ертөнц үүсэх тухай уран зохиомол тайлбар юм (Словарь иностранных слов. -М.: Рус.яз, 1989 толийн 597 дахь талд үзнэ үү).

<sup>12</sup> Каган М.С. Философская теория ценности. -СПб.: ТОО ТК “Петрополис”, 1997. номын 11 дэх талд.

<sup>9</sup> Мөн тэнд

<sup>10</sup> Мөн тэнд, 10 дахь талд

дээр дурдсан ухамсарын хэлбэрүүд тус бүрийн онцлогийг ойлгохыг эрмэлзжээ. Гэхдээ тэдгээрийн холбоог нэгдмэл үнэлэмжийн харилцааны янз бүрийн илрэл гэж хараахан ухамсарлаагүй ба “үнэлэмж” гэдэг ойлголт философи категорийн утгыг олоогүй байна. Гэвч энэ зорилтыг хэрэгжүүлэх зохих алхмууд гарч байсныг үгүйсгэх хэрэггүй юм. Тухайлбал, зан суртахууны үнэлэмжийн тухай италийн гуманистуудын эргэцүүлэл (Л.Валла), сайхан нь шашны үнэлэмжээс үл хамаарах өвөрмөц үнэлэмж болох тухай (Л.Б.Алберти), зөвхөн шашнаас төдийгүй, ёс суртахуунаас үл хамаарах Н.Макиавеллийн улс төрийн үнэлэмжүүд зөвшөөрөгдөх болсон байдаг.

ХҮП-ХҮШ зуунд ч үнэлэмжийн тухай нэгдмэл онол гарч чадаагүй байна. Яагаад гэвэл сайхан, сайн, үнэнч шударга, нийгмийн дэвшлийн тухай төсөөлөлүүд ухамсрын төвд бус байгаад байлаа, тэр үед шинжлэх ухааны сэтгэлгээ мистикийг шахан түрж, оюун ухааны хүчинд тулгуурласан байгалийн тухай танин мэдэхүй, математик мэдлэг шашны бишрэлийн оронд доминант нь болсон байлаа.

Соён гэгээрүүлэлтийн үед “оюун ухааны гэрэл” гэдэг томъёолол ноёлох зүйрлэл болж, хүний өөрийнх нь оршихуй Р.Декартын *cogito ergo sum* гэсэн алдарт томъёоллоор түүний сэтгэхүйгээс үүдэлтэй нь зөвшөөрөгдсөн. Энэ эрин үед теологийн *Homo Dei*-г К.Линнейн *Homo sapiens*-аар сольж хүний мөн чанарыг тодорхойлсон. Европын ХҮП-ХҮШ зууны бүхий л соёл зөвхөн байгаль төдийгүй, нийгэм болон хүний ертөнцийг танин

мэдэхүйн дээшлэлтээр тодорхойлогдож байжээ. Францын нэвтэрхий толь зэрэг соён гэгээрүүлэгчдийн гайхамшигт бүтээлүүдийг дурдаж болно. ХҮШ зууны дунд үе гэхэд л рациональ-сциент баримжааллын нэг талт байдал ухамсарлагдаж, хүн ба түүний оюуны ертөнц бусад хүмүүс хийгээд байгальтай харьцах холбоог олж хайх их ажил эхэлжээ. Английн сэтгэгчид таашаалын онолыг боловсруулж, этик, эстетикийн асуудалд шуурхайлжээ. Германы философич А.Баумгартен эстетикийг философийн биеэ даасан ухаан болгохын зайлшгүйг үндэслэж, И.Кантын сургаал Европын соёлын түүхэн шинэ үе болох романтизмын онолын үндсийг тавьж, Сэргэн мандалтын үеийн философи сэтгэлгээний ололтыг нэгтгэн дүгнэжээ.

И.Кант зан суртахууны “практик оюун ухаан” болон эстетик “бодомжийн чадвар”-ын үйл ажиллагааг ертөнцийг танин мэдэх “цэвэр оюун ухаан”-аас зарчмын ялгаатайг илрүүлж, тэгснээрээ соёл дахь түүний эрх, үйлчлэлийн хүрээг хязгаарлажээ. Романтизм энэ замаар цаашилж, сэтгэхүйн танин мэдэх үйл ажиллагааны боломж, хүний оюуны амьдралын сэтгэл хөдлөлийн идэвхит чанарыг туйлчилдаг Сэргэн мандалтын рационализмыг шийдвэртэй сөрж, үнэлэмжийн онол төрөн гарах хөрсийг бэлтгэсэн байна. Романтизм нь түүхийг өвөрмөц тусгай үнэлэмжтэй соёлын нэг хэв маягаас нөгөөд зүй ёсоор солигдох солигдолт болгосон ба үнэлэмжээрээ Өрнөдийхэнээс ялгаатай ч, тэдэнтэй адил тэгш эрх бүхий соёлын хэв маягтай Дорно дахинд түүнийг нь харийн, ердийн бус

гэсэнгүй, нэгэн зэрэг хүлээн зөвшөөрчээ. Романтизмын эмотивизм, историзм болон түүний ертөнцийг ойлгохуйн релятивизм зэрэг нь субъектээс объектод (танин мэдэхүйгээс гадуур) харьцах өнцгийг өөрчилж, онтологи болон гносеологи үзэл баримтлалыг уламжлалт байгууламжийн хүрээнээс гарахыг тулгасан байна.

Ингээд баримттай, юмслал хэлбэртэй бодит ахуйгаас зарчмын хувьд ялгаатай үнэлэмжийн үзэгдлийн өвөрмөц байдлыг илрүүлж, философийн жинхэнэ онол үүсэн бүрэлдсэн нь XIX зууны 60-аад онд германы философич Г.Лотцегийн бичсэн “Практик философийн үндэслэлүүд” гэдэг нэртэй шастираас эхтэй юм. Аксиологийн зэргэлдээх философийн салбар болох танин мэдэхүйн онол аль хэдийнээ онолын хувьд биеэ даасан бөгөөд ХҮП зуунд философи мэтгэлцээний төвд оршиж байсан байтал аксиологи асуудал ингэж чухалчлагдах нь гарцаагүй бизээ.

### ДҮГНЭЛТ

1. Үнэлэмжийн янз бүрийн төрлийн тухай бодомжийг эртний Грек, Ромын сонгодогууд, Дундад зууны теологууд, Сэргэн мандалтын үеийн сэтгэгчид, Шинэ үеийн философичдын бүтээлээс олж үзэж болох боловч тэдгээр нь үнэлэмжийн янз бүрийн төрлүүд дэх нийтлэг тал, тэдгээрийн холбоог нэгдмэл үнэлэмжийн харилцааны янз бүрийн илрэл гэж хараахан ухамсарлаагүй ба энд “үнэлэмж” гэдэг ойлголт философи категорин утгыг олоогүй байна;

2. Үнэлэмж бол ахуйн бусад хэлбэрүүдээс ялгаатай, өөр ертөнц байх

бололцоотой юм. Иймээс “Үнэлэмжийн ертөнцийг” судлаач Л.Столович, А.Уайтхед нарын адилаар “Аксиосфер” гэж нэрлэсэн үзэл баримтлалтай санал нэг байна;

3. Геологийн хувьд үнэлэмжийн онолыг боловсруулах дөхүү боломж байгаа ч “Бурхан тэнгэр” гэсэн ганц үнэлэмж буйн улмаас үнэлэмжийн төрлүүд дэх нийтлэг талыг хүлээн авах бололцоо хомс байх бололтой;

4. Энд дурдагдан буй түүхэн үе болгон ирээдүйд “Үнэлэмжийн философи” үүсэн бүрэлдэх урьдчилсан боломжийг ахиулсаар ирсэн нь үнэн хэдий ч Соён гэгээрүүлэлтийн үеийн философи сэтгэлгээний гарамгай ололтууд чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой байна.

### НОМ ЗҮЙ

1. Д.Алтангэрэл. Англи монгол толь. – УБ.: Интерпресс, 2001.
2. А.Винокуров. Англо-русский, Русско-английский словарь. М.: Мартин, 2014.
3. Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. УБ., 1982.
4. Т.Дорждагва. Соёл судлал. Сурах бичиг. -УБ.: БИТПРЕСС, 2013.
5. Каган М.С. Философская теория ценности. - СПб.: ТОО ТК ”Петрополис”, 1997.
6. Краткий русско-немецкий и немецко-русский словарь. –М.: Государственное издательство иностранных и национальных словарей, 1958.

7. Марксист-Ленинист философи. Дialectик материализм. –УБ., 1971. English dictionary. – Moscow: Soviet encyclopedia publishing house, 1970.
8. Марксист-Ленинист философи. Түүхийн материализм. –УБ., 1973.;
9. Марксист-Ленинист философи. Дialectик материализм. –УБ., 1981.
10. Марксист-Ленинист философи. Түүхийн материализм. –УБ., 1983.
11. Марксист-Ленинист философийн үндсүүд. УБ., 1983.
12. Марксистско-Ленинская философия. Дialectический материализм. Издание третье, доработанное. -М.: Издательство “Мысль”, 1974.
13. Марксистско-Ленинская философия. Исторический материализм. Издание третье, доработанное. -М.: Издательство “Мысль”, 1971.
14. Русско-английский словарь. Russian-English dictionary. – Moscow: Soviet encyclopedia publishing house, 1970.
15. Ц.Цэдэндамба. Монгол-орос-англи толь. – УБ., 1986. 244 дэх талд;Oxford Monsudar. English-Mongolian Dictionary. УБ., 2006.
16. Э.Чинбат. Англи-Монгол толь. УБ.: Цээл эрдэнэ, 2001.
17. Collins Gem. German dictionary. German-English, English-German. - London and Glasgow, 1988.
18. Collins Gem. Russian dictionary. Русско-английский, Англо-русский. – Glasgow: Harper Collins publishers, 2009.
19. Cambridge Advanced Learner’s Dictionary. – Cambridge, New-York, Melburne, Madrid: Cambridge University Press, 2003.

### ABSTRACT

The authors of the article “The premise of the philosophy of value,” gave a brief description of the concept of value in the specific historical period and expressed their views on the concept of those authors who published their works before. In this regard, the authors of this article came to four conclusions.